

Хилмийн эрх зүй**ГЭР БҮЛ БА ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН***/алслагдсан сумдын жишээ нь дээр/***Л.Лхагвасүрэн***Хилийн албаны сургуулийн**Ар тал, эдийн засгийн тэнхимийн дэд профессор,**Хил судлал, боловсрол судлалын магистр, хошууч*

Товч утга: Миний судалгааны ажилд Монгол Улсын сүүлийн 5 жилийн гэр бүл төлөвлөлтийн байдал түүнийг дагасан шилжилт хөдөлгөөний талаар судалж түүнд үнэлэлт дүгнэлт өглөө. Судалгаанаас харахад сүүлийн 5 жилийн хугацаанд өмнөх оны мөн үеэс гэр бүл салалт нь харьцангуй ихсэж, гэрлэлтийн тоо нь буурч хоорондын хамаарал нь урвуу хамааралтай байна. Энэ хамаарал нь хилийн анги салбарт тодорхой хэмжээгээр оршиж байгааг анхаарал татаж байна. Монгол Улсад өнөөдрийн байдлаар гэр бүлээс гадуурх амьдралыг хуульчилсан эрх зүйн акт байхгүй байна. Төрөөс залуу гэр бүлийг дэмжих талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон бусад нөлөөлөх хүчин зүйлийн талаар товч өгүүлэх болно.

Түлхүүр үгс: Залуучууд, гэр бүл, шилжилт, хөдөлгөөн, хил хамгаалах байгууллага.

Abstract: In my research, the family of Mongolia over the past five years analyzed the planning situation that followed him and evaluated him. Studies have shown that over the past five years, divorce rates have increased relatively from the same period the previous year, and the correlation between the number of marriages decreases is treacherous. It's noteworthy that this dependency is somewhat present in the border class sector. In Mongolia today, there is no legal action against extramarital life. The Government will provide a brief overview of the measures being taken to support young families and other influencing factors.

Keywords: Youth, family, migration, movement and border protection organization..

Өнөөгийн Монгол Улсын нийгэмд төрөлт буурч, хүн амын хөгшрөлт, гэр бүл, хүн амын хомсдол, эдийн засгийн тогтворгүй байдал, бүс нутгийн хүмүүсийн

харилцаа суларч байна. Хүмүүсийн амьдралыг тойрсон хүрээлэн буй орчны томоохон өөрчлөлтүүдийн дунд амьдралын янз бүрийн асуудал үүсэн бий болж байна.

Нэг талаараа ард иргэдийн амьдралд төрийн тогтолцоо болох тэтгэвэр, эмнэлгийн даатгал, халамжийн тогтолцоо зэрэг нийгмийн хамгааллын тогтолцоо нь иргэдийн асуудлыг дэмжих үүднээс хувьсан өөрчлөгдөж байгаа боловч ар араасаа гарах нийгмийн сөрөг зүйлсээс шалтгаалж тогтвортой байдал ганхаж, хөдөлмөр эрхлэлтийн байдал хүндэрч, орон нутгийн засаг захиргаа санхүүгийн хувьд бэрхшээлтэй байдалд орж байна. Үүнийг дагаад ард түмний амьдралыг тэтгэдэг нийгмийн тогтолцоо маш их ганхаж олон төрлийн эрсдэлд оруулж байгаа юм.

Энэ нийгмийн ганхалтыг үед хамгийн эмзэг дусах хэсэг бол Монголын залуу гэр бүлүүдэд хамгийн хүнд тусах магадлалтай юм. Судлаач миний судалгааны ажилд Монгол Улсын залуу гэр бүлийн өнөөгийн байдал тэдэнд үзүүлэх нийгмийн халамжийн байдал төрөөс авах дэмжлэгийн талаар болон хилийн салбар, ангид шинээр гэр бүл болж байгаа залуусыг хэрхэн урамшуулж нийгмийн баталгааг хангах талаар судлахыг зорилгоо.

Судалгааны ажлын арга зүй: Баримт материал судлах, ажиглалтын арга, түүхэн ба логик арга, түүврийн арга, статистик боловсруулалтын аргуудыг ашигласан.

Судалгааны үр дүн: Гэрлэлт гэж юу вэ? Гэрлэлт гэдэг бол ирээдүйн амьдралын аз жаргалын эхлэл юм. Бид та бүхэнд гэрлэлтийг хэдхэн өгүүлбэрээр, хөгжилтэй байдлаар маш товчоноор тайлбарлая.

1. Зөвхөн түүний тухай бодно.
2. Түүнийг гэртээ ирэхэд нь гэрийн шаахайг нь авчирч өгнө
3. Бие биедээ сайхан санагдах өхөөрдсөн нэр өгнө
4. Нэг зүйлрүү тэмүүлж амьдарна
5. Хамтдаа дэлгүүр хэснэ
6. Түүнийгээ тэвчээртэйгээр хүлээнэ
7. Хамтдаа TV-н нэг суваг үзнэ.
8. Асуудлаа хамтдаа шийдвэрлэнэ
9. Насан туршдаа хамтдаа байна
10. Гэрлэх зорилгын талаар явуулсан сэтгэл судлаач Мацковскийн

судалгаагаар:

- Хvvхэдтэй болж удам угсаагаа vргэлжлvvлэх-66%
- Эсрэг хvйсийн хvнтэй дотны харилцаатай байх хэрэгцээ- 37%
- Гэр бүлээр дамжуулан хүн өөрчлөгдөн, төлөвшдөг- 27%
- Ганцаардлаас ангижрах зорилготой-26%
- Шинэ амьдрал бүтээх зорилготой-24 %
- Хайртай хүнээсээ хагацахыг хүсээгvй учраас-19% нь гэр бүл болсон гэж

хариулсан байна. Гэрлэлтийн үр дүнд бий болсон тодорхой эрх үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг “гэр бүл” гэнэ.

Энэ судалгаанаас үндэслээд гэр бүл гэж чухам ямар үүрэгтэй мөн үг зүйн утга агуулгыг нь судалж үзэхэд

Гэр бүл: “Гэрийн доторх хүн ам”¹⁴³

Гэр бүл гэж хамтдаа амьдардаг, бие биетэйгээ ямар нэгэн холбоотой (цусан холбоотой, гэрлэсэн г.м.) бүлэг хүмүүс буюу амьтдыг (зарим амьтад нь үр төлөө асарч гэр бүлтэй төсөөтэй зүйлийг бүрдүүлдэг) хэлнэ. Гэр бүлийн анхдагч үүрэг нь үр удмаа нөхөж үйлдвэрлэх, өсгөж хүмүүжүүлэх явдал юм гэж ойлгож болохуйц байна.

Өнөөдөр Монгол улсад өдөрт дунджаар 40 хос гэрлэлтээ батлуулж байхад 10 нь гэр бүлээ цуцлуулдаг байна. Энэ нь жилд 16-17 мянган хос гэрлэлтээ батлуулдаг ч дөрвөн мянга нь гэр бүлээ цуцлуулдаг гэсэн үг.

Орчин цагт гэр бүл төлөвлөж амьдарна гэдэг нь нийгмийн нэг давалгаанд нэгдэн орж амьдралын өмнө тэнцвэртэй орших уу эс орших уу гэдэг нь их чухал болсон байна. Монгол Улсад сүүлийн таван жилийн байдлаар харуулахад


Хүснэгт.1 Гэр бүл салалт тоон судалгаа

Статистик үзүүлэлт	Насны бүлэг	2017	2018	2019	2020
Эрэгтэй	18-19	181	188	221	156
	20-24	4,783	4,730	4,511	3,510
	25-29	8,275	8,018	7,481	5,168
Эмэгтэй	18-19	652	602	641	531
	20-24	6,619	6,408	6,279	4,657
	25-29	7,390	7,534	6,827	4,728

Дээрх судалгааг нэгтгэж графикаар харуулбал

Зураг.1 Гэр бүл салалт хүйсийн харьцаагаар

Судалгаанаас харахад 25-29 насны эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гэр бүл салалтын тоо харьцангуй их байгаа нь ажиглагдаж байна. Сүүлийн жилүүдэд гэр



¹⁴³ Монгол хэлний их тайлар толь

бүл салалтад олон хүчин зүйл нөлөөлж байгаа боловч эсрэгээрээ гэрлэлтийн байдлыг үзэхэд

Хүснэгт.2 Гэрлэлтийн байдал /Улсын дүнгээр/

Аймаг	Аймгийн код	Гэр бүлийн байдал	2017	2018	2019	2020
Улсын дүн	0	Гэрлэлт	20,470	21,020	20,043	14,252

Хүснэгт.3 Гэрлэлтийн өсөлт бууралт

Аймаг	Гэр бүлийн байдал	Аймгийн код	2017 Өсөлтийн хувь	2018 Өсөлтийн хувь	2019 Өсөлтийн хувь	2020 Өсөлтийн хувь
Улсын дүн	0	Гэрлэлт	0	2.7	-2.1	-30.4

Улсын дүнгээр 2017 оныхтой харьцуулахад гэрлэлтээ батлуулсан айл өрх 30,4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ тоо жил ирэх тусам гэрлэлт баталгаажуулж буй айл өрхийн тоо буурсаар байна. Хил Хамгаалах байгууллага хилийн анги, салбар дээр алба хааж байгаа залуу гэр бүлүүдэд ч гэсэн дээрх судалгаануудад хамааралтай бөгөөд сүүлийн жилүүдэд хилийн анги, салбарт гэр бүл салалт огцом нэмэгдэх хандлагатай байна. Судлаач миний бие уг асуудлыг хөндөх болсон гол шалтгаан нь хил дээр алба хааж байгаа залуу гэр бүлүүдэд нөлөөлж буй хүчин зүйлүүд болон түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар санал зөвлөмж хүргэх зорилготой юм. Гэр бүл салалтад нийгмийн олон хүчин зүйлсээс болсон байх боломжтой. Гэр бүл салалтад дараах зүйлс нөлөөлж байна. Үүнд

- Соёлын ялгаа, Харь орны хүнтэй гэрлэсэн, Мөн хоёр өөр гэр бүлийн соёлын мөргөлдөөн.
- Гэр бүлийн гишүүд хариуцлагаа бүрэн ухамсарлаагүй
- Гэрлэх хүнээ сайн таньж мэдээгүй
- Санхүүгийн хомсдол, цалин орлого, амьдралын баталгаа
- **Шилжилт хөдөлгөөн**
- Архидалт, муу зуршил
- Гэр бүлээс гадуурх харилцаа, Хууралт.
- Хэрүүл маргаан, Үл ойлголцол.
- Хүчирхийлэл, Дарамт шахалт гэх зэрэг хүчин зүйлүүд нөлөөлөх боломжтой юм. Дээрх олон хүчин зүйлээс зөвхөн шилжилт хөдөлгөөний талаар товч судалбал.

Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал, түүний шалтгаан нь

Шилжилт хөдөлгөөний суурь шалтгааныг тодруулснаар богино хугацаанд сааруулах, дунд хугацаанд зогсоох, удирдах төрийн нэгдсэн бодлого боловсруулахад чухал ач холбогдолтой. Иймд энэхүү хэсэгт хүн амын шилжих хөдөлгөөний шалтгааныг улсын хэмжээнд (том зургаар) авч үзсэн болно.


Уугуул нутгаа орхин шилжигчдийн насны бүтцийн тархалтыг ажиглахад дийлэнх хэсгийг ихэвчлэн залуу, хөдөлмөрийн насны хүн ам эзэлж байна. Шилжин суурьшиж байгаа өрхийн хүн амын дийлэнх хувийг 25–39 насны залуучууд ба тэдгээрийн даган шилжиж буй 10 ба түүнээс доош насны хүүхдүүд, ахмад настнууд эзэлж байна.

Шилжигч өрхийн хүн амын ачаалал харьцангуй өндөр байгаа нь тус чиглэлээр хийгдсэн судалгаагаар нотлогдож байна¹⁴⁴. 0–14 насны хүүхэд, 65–аас дээш насны хүн ам нь гэр бүлийн залуу өрхийг даган өөр орон нутагт шилжин явдаг гэж үзвэл, шилжигч өрхийн бүтцэд ахмадууд болон хүүхдүүдийн эзлэх тоо шилжигч бус өрхийн бүтцээс 13 хувиар өндөр байна¹⁴⁵. Шилжигч бус өрхийн хөдөлмөрийн насны 10 хүнд 6–аас доош ахмад настан болон хүүхэд ногдож байхад шилжин явсан өрхийн 10 хүн тутамд 7 ахмад настан болон хүүхэд ногдож байна.

Шилжигсдийн дунд боловсролтой шилжигчдийн эзлэх дүн өндөр байгаа нь залуучууд сурч боловсрох боломжоор илүүтэйгээс гадна их дээд боловсрол эзэмшихээр шилжих хөдөлгөөнд илүү оролцож байгааг харуулж байна. Шилжигсдийн 38 орчим хувь нь бүрэн дунд боловсролтой байгаа бол тэдний 23% нь дээд боловсролтой, түүний дотор бакалавр, магистрын зэрэгтэй хүмүүс байна. Энэ тоо баримт нь шилжигчдийн дийлэнх залуу насны хүн ам байгаа учир тэд ахмад настай хүмүүстэй харьцуулахад, боловсрол эзэмших боломжоор илүү, мөн мэргэжил үйлдвэрлэл, их дээд сургуульд суралцахын тулд шилжилтэд оролцдог эсвэл мэргэжлийн дагуу ажиллах боломжийг хайн шилжиж байгааг харуулна (ОУШХБ, 2016 он).

¹⁴⁴ Монгол Улс: хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа, 2016

¹⁴⁵ Монгол Улс: хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа, 2016

Зураг. 2 Шилжин явагчдын боловсролын байдал


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөдөөнөөс хот, суурин газарт шилжих хөдөлгөөний шалтгаан

Хүн ам зүйн шилжих хөдөлгөөнийг хөдөөгөөс сум, аймгийн төврүү чиглэсэн хөдөлгөөн, Аймгийн төвөөс томоохон хот,нийслэл рүү зэрэг хотруу чиглэсэн хөдөлгөөн гэж хоёр ангилж үзсэн. Энэхүү 2 төрлийн шилжилт хөдөлгөөн нь харилцан уялдаатай байгаа бөгөөд ихэвчлэн шилжигчид эхний ээлжинд сум, аймгийн төврүү шилжилтийг хийж, дараагийн ээлжид аймгийн төвөөс хот руу чиглэсэн шилжилтийг үйлдэж байна.

Хөдөөгөөс сум, аймгийн төв рүү шилжиж байгаа шалтгааны 81.7 хувийг эдийн засгийн, 10 хувийг гэр бүлийн шалтгаан эзэлж байна. Гэр бүлийн шалтгаан нь эхнэр эсвэл нөхрийн ажлын байрыг даган шилжих хөдөлгөөн эсвэл нэгэнт аймаг, сумын төвд ажил хөдөлмөр эрхэлж, амьдран сууж буй гэр бүлийн гишүүнтэйгээ ойртох шалтгаан зонхилж байна.

Харин томоохон хот,нийслэл рүү шилжих шалтгааны 46.9 хувь нь эдийн засгийн, 25.8 хувь нь гэр бүлийн, 12.5 хувь боловсрол, эрүүл мэндийн 11.5 хувь амьжиргааны нөхцөл байдлаа сайжруулах, 3.3 хувь бусад нөхцөлөөр тайлбарлагдаж байна.



Зураг. 3 Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудруу шилжигсдийн шалтгаан


Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

Зураг. 4 Аймаг, аймгийн төврүү чиглэсэн шилжих хөдөлгөөний шалтгаан

Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

Эдийн засгийн шалтгааныг авч үзвэл :

- Цаг уурын хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан малаа алдсан иргэд цалин хөлстэй ажил хийхээр хот, суурин газар руу шилжих;
- Дээд болон дунд боловсрол эзэмшсэн залуус орон нутагт нь ажлын байр



байхгүйгээс хот суурин газарт ирж мэргэжлийн дагуу ажил хөдөлмөр эрхлэх;

- Амьжиргааны болон байр орон сууцны нөхцөлөө сайжруулж, хүүхдээ цэцэрлэг сургуульд ойртуулах зэрэг орж байна.

Шилжилт хөдөлгөөний нөгөө өнцөг нь тусдаа ажиллаж амьдарч байгаа залуу хосууд маш их байна. Улаанбаатар их сургуулийн Гэр бүлийн тэнхимийн

эрхлэгч доктор, дэд профессор Б.Оюун-Эрдэнийн ярилцлагад дурдсанаар “Шүүхээр гэр бүлээ цуцлуулж байгаа хосуудын мэдүүлэг болон судалгаанаас авч үзэхэд гурван шалтгаан байна. Нэгдүгээрт, гэр бүлийн хүчирхийлэл, архидалт, үл ойлголцлын асуудлууд байна. Хоёрдугаарт, гэрлэлтээс гадуурх бэлгийн харилцаанд ордог. Гуравдугаарт, хол тусдаа байсан гэсэн шалтгаанаас үүдэж гэр бүл салж байна”¹⁴⁶ гэж дурдсан байдаг. Хилийн анги салбарт алба хааж байгаа залуу офицеруудын 30-40 хувь нь гэр бүлээсээ тусдаа ганцаараа амьдарч байгаа нь онцгой анхаарал татахуйц байгаа юм. Ийнхүү хөдөлмөр шилжилтийн улмаас тусдаа амьдарч байгаа гэр бүлүүд уул уурхай, төрийн болон цэргийн байгууллага, гадаадад ажиллаж буй залуучууд гэх зэрэг Монгол Улсын гэрлэх насанд хүрсэн болон гэрлэлтээ батлуулсан хүмүүсийн 20 гаруй хувийг эзэлж байгаа нь Улсын хувьд ирээдүйд хүн амын өсөлтөд сөргөөр нөлөөлөхүйц байгаа юм.

Төрөөс залуу гэр бүлийг залуу гэр бүлийг дэмжсэн орчин, нөхцөл бүрдүүлж, цогц үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх чиглэлээр хангахын тулд дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.¹⁴⁷

- Алсын хараа 2050
- Хүүхдийн тоо, наснаас хамааруулан хөнгөлөлт эдлүүлэх, хуримтлал бий болгох тогтолцоо бүрдүүлнэ.

- Залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжих, бодит хуримтлал бий болгоход чиглэсэн “Залуу гэр бүл” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

- Ажил хөдөлмөр эрхэлдэг эцэг эхэд ажлаар гэрийн амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлнэ. (эцэг эхийн ажлын цагийн зохицуулалтыг оновчтой, сонголттой болгох, хагас цагийн хөдөлмөр эрхлэлт, зайнаас ажиллахыг дэмжих),

- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Оюутны хөдөлмөрийн бирж” байгуулж хөгжүүлнэ.

ГЭР БҮЛ

ЗОРИЛТ 2.3 Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ ТОГТОЛЦОО	БҮТЭЭЛЧ ГЭР БҮЛ	ӨРХ, ГЭР БҮЛ, ЧАНАРТАЙ АМЬДРАЛ
Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжих үе	Идэвхтэй бүтээлч иргэн, гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх үе	Нийгмийн идэвхтэй, бүтээлч гэр бүлийг дэмжих орчинг бүрдүүлэх үе
1. Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн судалгаа, нотолгоонд суурилсан гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашгтай тогтолцоо бүрдүүлэх	1. Хүн амын бүлгүүдийг, тэр дотроо залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжсэн, бүтээмжтэй ажил, хөдөлмөр эрхлүүлж, ижил үнэ цэнтэй ажилд ижил цалин хөлс олгох тогтолцоог бүрдүүлэх олон талт хөгжил, хамгааллын цогц тогтолцоо төлөвшүүлэх	1. Хүн амын амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг хэрэгжүүлж, дэлхийд үнэлэгдэхүйц Монгол иргэнийг төлөвшүүлэх
2. Залуу гэр бүлийг дэмжсэн орчин, нөхцөл бүрдэж, цогц үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх	2. Гэр бүл, хувь хүний хөгжлийн хэрэгцээг дэмжсэн орчин, нөхцөл бүрдүүлж, цогц үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх	

¹⁴⁶ <http://newsmedia.mn/9245>

¹⁴⁷ Алсын хараа 2050

- Гадаадад сурч, ажиллаж, амьдарч байгаа иргэдийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.

- Залуу гэр бүлд сэтгэл зүйн чиглэлээр зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, мэргэжлийн, судалгааны болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

Ганцхан төрөөс ч гэлтгүй бусад төрийн бус байгууллага болон олон улсын байгууллагуудаас залуу гэр бүлийг дэмжих талаар олон төрлийн хөтөлбөр, төсөл арга хэмжээнүүдийг авч байгаа боловч сүүлийн жилүүдэд гэрлэлтээ батлуулж буй залуучуудын тоо эрс буурч эсрэгээрээ гэр бүл салалт олширч байгаа нь анхаарал татаж байна. Учир нь дэлхий нийтийг хамарсан цар тахал болон нийгэм эдийн засгийн хүндэвтэр байгаа өнөө цагт залуу гэр бүлүүдэд санхүүгийн эрх чөлөөнд хүрэх хүсэл эрмэлзлэлийг нухчин дарж үгүйсгэж байна. Нэг өрхийн дундаж орлого өнөөдрийн байдлаар 1,508,837 төгрөг байгаа нь зах зээлийн нийгэмд шилжсэн өнөө үед бол өдрийн хэрэглээгээ хангахуйц л хэмжээнд байна. Гэтэл хүний хэрэгцээ хязгааргүй байдаг нь өрх бүр өөрсдийн орлогыг тодорхой хувиар өсгөх, хязгааргүй хэрэгцээгээ хангах, нийгэм орчиндоо дасан зохицон амьдрахын тулд гэр бүлийн нэг гишүүн нь алслагдсан сум эсвэл хилийн дээс алхан ажиллах болсон байна. Үүнээс үүдэж гэр бүлийн уур амьсгалд өөрчлөлт орж энэ өөрчлөлт нь тодорхой хугацааны дараа салалт болон хувирч байна.

Аливаа гэр бүл салалтын гол хохирогч нь хүүхэд юм гэдгийг сүүлийн үед нийтэд ил болж байгаа хүүхдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэргүүд бэлхнээ батлан харуулж байна. Алслагдмал байдалд ажиллаж байгаа гэр бүлийн хүүхдүүд хүртэл жирийн хүүхдүүдийг бодвол тодорхой хэмжээний сэтгэлийн шархтай эрх чөлөө хязгаарлагдмал байдалтай байгаа нь тус сэдвийг хөндөхгүй байхын аргагүй юм.

Гэр бүл салалт зөвхөн Монгол Улсад сүүлийн жилүүдэд ихсэж байгаа юм биш дэлхий нийтээр гэр бүл төлөвлөлт улам хөгширч ганцаарчилсан хувь хүнээрээ амьдрах байдал давамгайлсан шинж чанартай байна. Гэхдээ дэлхийн ихэнх орон өөрсдийн асуудлаа шийдвэрлэж чадсан байдаг жишээ нь Австралид гэр бүлийн мэргэжлийн үйлчилгээ маш сайн хөгжсөн бөгөөд гэр бүлийн харилцааны төрийн болон төрийн бус олон тусгай байгууллага ажилладаг байна. Тэдгээр байгууллагаас гэр бүлүүд хүүхэд хүмүүжлийн тухай, гэр бүлийн маргааны үед асуудлаа хэрхэн шийдвэрлэж, харилцаагаа сайжруулах талаар олон төрлийн зөвлөгөө авах боломжтой байдаг аж. Энэ тухай Австрали улсын шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, хуульч, сэтгэл зүйч Катерин Жонсон "Гэр бүлд асуудал үүсэж, хосууд салах эсэх нь өөрсдийнх нь сонголт байдаг ч салсныхаа дараа тэд хамтдаа үр хүүхдэдээ анхаарал, халамж тавьж, цаашдын амьдралаа ямар нэг сэтгэлийн шархгүй өнгөрүүлэх хэрэгтэй. Салсан ч тэд хүүхдийнхээ хувьд нэг гэр

бүл хэвээрээ байх ёстой. Ийм зарчмыг бид баримталж, зөвлөгөө өгч ажилладаг”¹⁴⁸ гэж тэмдэглэсэн байдаг.

Аль ч улс үндэстэнд, ямар ч гэр бүл сайхан харилцаатайгаа үлдэж салдаггүй. Харин салах үед нь тэднийг салсан ч эцэг, эх хэвээрээ үлдэнэ гэдгийг хажуугаас нь мэргэжлийн хүн хэлэх хэрэгтэй. Энэ бол гэр бүлийг дэмжих үйлчилгээний хамгийн чухал асуудал. Гаднын улсуудад гэр бүл маргалдах тохиолдолд хүүхдийнх нь хүмүүжилд сөргөөр нөлөөлдөг тухай эцэг, эхэд нь зөвлөж, зан үйл засах сургалтад хамруулдаг үйлчилгээ бий. Үүнийг хуулиар нь зохицуулсан байдаг бөгөөд шүүхийн шийдвэрээр гүйцэтгэдэг.

Өөрөөр хэлбэл, гэр бүл бол маш үнэ цэнтэй бөгөөд бат бөх харилцаан дээр тулгуурладаг. Харин тэр үнэ цэнийг нь гэр бүлийг дэмжих үйлчилгээгээр дамжуулж ойлгуулж байх учиртай гэж үзэж байна.

Дүгнэлт

Орчин үед залуучуудын гэр бүл төлөвлөлт хэт оройтож нийгэмд ганцаараа амьдрах хүсэл эрмэлзэл бий болсон байна. Нийгмийн шилжилт хөдөлгөөн нь залуу гэр бүлийн тогтвортой байдлыг алдагдуулж сөргөөр нөлөөлж байна. Энэ нь өөр өөр орчинд бие биеэсээ зайтай байгаа нөхцөлд сэтгэл зүйн өөрчлөлтөд орж гэр бүл салалт олширч байна. Нөгөө талаасаа эдийн засгийн байдал шинээр залуу гэр бүл болсон айл өрхүүдэд хүндээр тусаж байгаа нь дээрх судалгаа болон олон улсын судлаачдын дүгнэлтэд гарч ирсээр байна. Тухайлбал цар тахал нь улс орны эдийн засагт нөлөөлөөд зогсохгүй айл өрхийг санхүүгийн гүн хямралд өртүүлж шинээр гэр бүл болсон залуус байр, хувцас хэрэглэл болон анхдагч болон хоёрдогч хэрэгцээгээ хангахад хүндрэл учруулж байгаа юм. Нийгмийн тойрсон гэр бүл салалт нь Хил Хамгаалах Байгууллагыг тойрч гаралгүй дайран өнгөрч байгаа нь илт харагдаж байна. Хилийн анги, салбарт алба хааж байгаа залуучуудын 40-50 хувь гэр бүлгүй эсвэл гэр бүлээсээ салж хоёрдогч амьдралыг сонгосон нь дээрх судалгаанаас харагдаж байна. Ирээдүйд энэ тоо улам өсөх хандлагатай байгаа юм. Хэрэв гэр бүл салалт одоогийн байдлаасаа илүү их нэмэгдвэл Үндэсний аюулгүй байдлын хэмжээнд хүрч болзошгүй юм.

Санал

Гэр бүл төлөвлөлт болон залуу гэр бүлийг дэмжсэн төрөөс олон төрөлт арга хэмжээг авсаар байгаа боловч сүүлийн 3 жилийн хугацаанд гэр бүл салалт нь харьцангуй ихсэж байгаа нь уг төсөл арга хэмжээнүүд нүдээ олохгүй байна уу эсвэл хэрэгжүүлэх арга хэмжээ нь буруу явагдаж байна уу ямартай ч судалгаанаас үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Хүн ам зүйн бодлогын хүрээнд:

- Тухайн нутаг дэвсгэрт ажиллаж буй төрийн албан хаагчдад бусад бүс нутгаас давуу урамшуулал олгох, байр орон сууцны хөнгөлөлттэй нөхцөл олгох, гэр бүлийн гишүүдийн төв рүү зорчих зардалд дэмжлэг үзүүлэх, жилд 1-ээс 2 удаа

¹⁴⁸ <https://ikon.mn/opinion/1rn6>

нарийн мэргэжлийн эмнэлгийн үзлэгт оруулах гэх мэт бодлогын арга хэрэгслийг ашиглах

- Гэр бүлээс гадуур харилцааны тухай хуулийн зохицуулалт хийх
- Төрөөс залуу гэр бүлийн санхүүгийн байдалд онцгой анхаарах /цар тахлын нөхцөл байдлын үед/
- Хилийн анги салбарт шинээр гэр бүл болж байгаа айл өрхөд тодорхой гэрээний үндсэн дээр өөрийн хүссэн газар нь 1-3 хувийн хүүтэй орон сууцны зээлд хамруулах
- Хил Хамгаалах Байгууллагад ажиллаж буй алба хаагчийн гэр бүлийн гишүүнийг ажлын байраар хангах, өөр байгууллагад шилжин ажиллахад дэмжлэг үзүүлэх зэрэг саналыг дэвшүүлж байна

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Арвай.Ш., (2013) он.Улсын хил, хязгаарын аюулгүй байдал, тулгамдсан асуудлууд шийдвэрлэх арга зам.УБ хот
2. Намжил Т., Оюунбилэг Г., (1999),“Монгол гэр бүл: цуврал-1”
3. Д.Ганбаатар., М.Баярсайхан., Э.Энхтайван., Л.Лхагвасүрэн., (2020) Хил орчмын бүс нутгийн эдийн засгийн хөгжил, Хил дагуух орон нутгийн хөгжлийн бодлого
4. Алсын хараа 2050
5. Монгол Улс: Хүн амын нэгдсэн тооллого, 2016, 2017, 2018, 2019, 2020
6. Монгол Улс: хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа, 2016
7. Монгол хэлний их тайлбар толь
8. <https://ikon.mn/opinion/1rn6>

---o0o---